



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/69

Шивээговь сум

Хээрийн дадлага сургалтад
 орон нутгийн хамгаалалттай бүрэлдэхүүнийг
 ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 11 дүгээр зүйлийн 11.3.3, 11.4.2, 22 дугаар зүйлийн 22.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн “Хээрийн дадлага сургуулилт зохион байгуулах тухай” А/176 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн хэмжээнд Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хээрийн дадлага сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрүүдэд зохион байгуулахтай холбогдуулан сумын Орон нутгийн тусгай хамгаалалттай бүрэлдэхүүнийг томилгоожуулан ажиллуулсугай.

2. Сургалтыг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, шаардагдах төсвийн задаргааг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтад оролцох бие бүрэлдэхүүн, техникийг томилгоожуулж, “Зарлан дуудах мэдэгдэл”-ийг хурдан, шуурхай хүргэж заасан байранд тогтоосон цагт бэлэн байлгах, сургалтад оролцох бүрэлдэхүүний хувийн хэрэгсэл, өмсөх хувцсыг улирлын байдалд тааруулан жигд хувцсаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

4. Арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах 1,200,000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангаж зарцуулахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй


5. Захирамжийн хэрэгжилтийг ханган, үр дүнг танилцуулан ажиллахыг ажлын хэсгийн дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн 1169 дугаар захирамжийн 1-р хавсралт



ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН “ХЭЭРИЙН ДАДЛАГА, СУРГАЛТ”
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн дарга:

Д.Отгонжаргал
(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Л.Бадамханд
(1 дүгээр багийн Засаг дарга)
С.Отгонбаатар
(2 дугаар багийн Засаг дарга)
Ч.Энхжаргал
(Шивээ Овоо хувьцаат компанийн Хүний нөөцийн албаны дарга)

Ш.Чинболд
(Илчлэг Шивээ Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал)

Ц.Түмэндэмбэрэл
БЗӨБЦТС-ТӨХК-ийн Говьсүмбэр салбарын Шивээговь хэсгийн дарга

П.Ганчимэг
(Эрүүл мэндийн төвийн дарга)

Д.Буяндэлгэр
(Ерөнхий боловсролын сургуулийн захирал)


Н.Амаржаргал
(Мэдээллийн технологи, олон нийттэй харилцах ажилтан)

Б.Баярцэцэг
(Нярав)

Нарийн бичгийн дарга:

Б.Шинэбаяр
(Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн дэд хурандаа)

Сумын Засаг даргын
*2024*... оны *05*-р сарын *24*-ны
 өдрийн *А/69* дугаар захирамжийн *2*-р хавсралт



Бараа материалын төсөв

Д/д	Материалын нэр	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хоолны зардалд	16	35000т	560000т
2	Ус	200ш	750т	150000т
Нийт				710000т

Тээвэр шатахууны төсөв

Д/д	Материалын нэр	Литр	Нэг брийн үнэ	Нийт үнэ
1	A/80	19,6л	2540т	50000т
2	A/92	58,5л	2560т	150000т
Нийт				200000т

Шагналын төсөв

Д/д	Материалын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Өргөмжлөлийн жааз	3ш	11500т	34500т
2	Шаазан аяга, хэвлэл	6ш	11000т	66000т
3	Халуунаа барьдаг аяга	6ш	21580т	129500т
4	Дэвтэр	6ш	10000т	60000т
Нийт				290000т
Бүх зардал нийт				1200000т